



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

“Монгол Улсын 2025 оны төвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын 1.1 дэх хэсэгт “чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх”-ийг Засгийн газарт даалгасан.

Иймээс, бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын орон тоог бууруулах шаардлагатай байна.

Түүнчлэн, Ажилгүйдлийн даатгалын сангийн 2024 оны олгогдоогүй тэтгэмж 19.2 тэрбум төгрөгийг 2025 оны 1, 2 дугаар сард олгосонтой холбоотойгоор тус сангийн 2025 оны төсөв хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр дутахаар байна.

Мөн 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авагчдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2325 хүнээр буурснаас тус сангийн зарлагад хэмнэлт бий болж байна.

Иймд Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагыг нэмэгдүүлэхгүйгээр сан хооронд зохицуулалт хийх, орлогод өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн орлого, зарлагын хэмжээнд оруулах өөрчлөлтийг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Нийгмийн даатгалын сангийн батлагдсан зарлагын хүрээнд сан хооронд зохицуулах өөрчлөлт хийх замаар зардлыг үр ашигтай, оновчтой зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---